



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/157

Мөрөн

**Монгол хэлний талаарх төрийн бодлого,
хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, 17 дугаар зүйлийн 17.1.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлиг, 2018 оны 46 дугаар зарлиг, Засгийн газрын 2013 оны 37 дугаар болон 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоол "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3", Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.10.1-2.10.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хөгжлийн бодлого, стратеги, урт болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлсон баримт бичгүүдэд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд монгол бичгээ сурах аян хөдөлгөөн өрнүүлж, төрийн байгууллагуудын албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг чадварыг үе шаттайгаар дээшлүүлэх, монгол хэл, бичгийн сургалтын чанарыг сайжруулах зэрэг зорилт арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлсүгэй

2. Сумын албан байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, гудамж, талбайн нэр, албан хаагчдын нэрийн хуудас, нутгийн брэнд бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа, өргөмжлөл, батламж, талархал зэргийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулсугай.

3. Монгол бичгийн эх бэлтгэх, алдааг хянах, засах ажлыг Хөвсгөл аймгийн Боловсрол, Шинжлэх Ухааны Газрын монгол хэлний боловсрол хариуцсан ахлах арга зүйчээс зөвлөмж авахыг аж ахуйн нэгж байгууллагын дарга удирдлагуудад зөвлөсүгэй.


4. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2017 оны 25 дугаар зарлигийн дагуу 9 дүгээр сарын 01-нд "Эх хэлний өдөр"-ийг сум, төрийн байгууллагын хэмжээнд тэмдэглэх, эх хэл, бичгээ сурч судлахыг уриалах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа, аяныг өрнүүлсүгэй.

5. Сумын хэмжээний аж ахуйн нэгж байгууллагуудад эх хэл, бичгийн чадварыг дээшлүүлэх, хэрэглээний орчин бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх зөвлөмжийг нэгдүгээр хавсралтаар, жил бүрийн хагас жил, жилийн эцсийн тайлангийн загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

6. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Р.Элбэг-Очир)-т даалгасугай.

ДАРГА

ДИДЭРМӨНХ



2023.06.26